



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН
МАТЕРИАЛ
2026

A vertical street lamp on the left side of the frame casts a wide, warm, yellowish-orange glow across the upper half of the image. The light source is a small, bright rectangle at the top of the lamp's curved arm. The glow fades into the dark background. Below the lamp, a path or road is visible, illuminated by the same light. The foreground is dark and textured, possibly grass or a rough surface. The overall mood is quiet and contemplative.

*Тэрэлтэй
амьдаръя*

**Хурлын тов:**

2026 оны 4 сарын 25-ны өдрийн
14:00 цагт

Хурал болох газар:

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг,
Баян зам 3-4,6 тоотод байрлах үйлдвэрийн байранд
хосолсон /танхим болон зайнаас/ хэлбэрээр хуралдана.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр:

2026 оны 4 сарын 3-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. “Анд Энерги” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх дүгнэлтийг хэлэлцэн батлах;
2. “Анд Энерги” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг сонгох тухай

АГУУЛГА

1. Компанийн танилцуулга
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай ТУЗ-ийн тогтоол
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар, танилцуулах баримт бичгийн жагсаалт
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл
8. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт
9. Компанийн 2025 оны санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт
10. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн тогтоол
11. ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулга

**ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ
БАРИМТ БИЧГҮҮД**

1. 2025 оны үйл ажиллагааны товч тайлан
2. 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан



КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Анд-Энерги ХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан ба Монгол улсдаа анхны бөгөөд цор ганц лед гэрэл, гэрэлтүүлгийн үйлдвэр юм.

2017 онд хувьцаат компани болж, үйлдвэрлэлээ өргөжүүлэн чанартай, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнүүдээр хэрэглэгчдэд үйлчилсээр байна. Одоогоор 659 хувьцаа эзэмшигчидтэй, орон нутгийн 20 гаруй иргэнийг байнгын ажлын байраар ханган ажиллаж байна. Бид гадна болон дотор зориулалтын лед гэрэл, гэрэлтүүлэг үйлдвэрлэхээс гадна бүх төрлийн гудамж, зам талбай, фасадын гэрэлтүүлэг, цахилгаан тоног төхөөрөмж угсралтын ажлуудыг стандарт, журмын дагуу, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж байна.

Манай компани нь эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлдэг магадлан итгэмжлэгдсэн байгууллага бөгөөд эрчим хүчний яамны тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулдаг. Мөн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд технологи нэвтрүүлсэн байгууллага юм.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Мэдлэгт суурилсан үнэ цэнэтэй бүтээлээр дэлхий ертөнцийг гэрэлтүүлнэ.

АЛСЫН ХАРАА

Бид Монгол улсын гэрэлтүүлгийн зах зээлийн чиг хандлагыг тодорхойлно

ҮНЭТ ЗҮЙЛС

- 💡 Зөв засаглал;
- 💡 Эрдэм, мэдлэг;
- 💡 Шинэ санаачилга, бүтээлч байдал;
- 💡 Хамтын хүч

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

- 💡 Харилцагч, хэрэглэгчийг инээмсэглэлээр угтаж, итгэлээр үдэх
- 💡 Эрүүл аюулгүй орчинг бүрдүүлж, ажилчдыг өсөн дэвших бодлого баримтлан ажиллах
Хамтын хүч, бүтээлч сэтгэлгээ, шинэ санал, санаачлагыг дэмжин ажиллах
Техник технологийн хөгжилтэй хөл нийлүүлэн, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг явуулах
- 💡 Хууль, дүрмийг чандлан сахиулан ажиллах

УРИА ҮГ

Гэрэлтэй амьдаръя.



МАНАЙ БҮТЭЭГДЭХҮҮН

Бид нийт 6 ангилалын 31 нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг монгол залуусын сэтгэл, оюуныг шингээн дотооддоо үйлдвэрлэж байна. Гэрэлтүүлгүүдийг хэрэглээ, орчны нөхцөл, техникийн үзүүлэлтээс хамаарч дотор болон гадна гэрэлтүүлэг гэсэн 2 ангилалд хуваана.

Гэрэлтүүлгийн үр ашгийн үзүүлэлтүүдийг манай улсад ганц байдаг гэрлийн чанар шалгах лабораторийн тоног төхөөрөмж ашиглан, тогтмол хэмжиж, хянаж байдаг нь бүтээгдэхүүний чанарыг өндөр түвшинд барих нөхцлийг бүрдүүлдэг. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ашиглагдаж буй түүхий эд материалууд нь өндөр температурын хэлбэлзэлд тэсвэртэй, удаан эдэлгээтэй, эрчим хүчний хэмнэлттэй байх зарчимд тулгуурладаг.

Тиймээс бид өөрсдийн бүтээгдэхүүний чанарт бүрэн итгэдэг ба баталгаат хугацаа олгодог. Одоогийн байдлаар манай компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг уул уурхай, боловсрол, эрүүл мэнд, худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 100 гаруй байгууллага, аж ахуй нэгжүүд тогтмол авч, гэрэлтүүлгүүдийг ашиглаж байнгын худалдан авалт хийж байна.



2024 он

Монголын Худалдаа Аж
Үйлдвэрийн танхимын Бүс,
орон нутгийн онцлох
“Энтрепренёр”-оор шалгарав



2020 он

Гэрлэн бүтээгдэхүүний
үйлдвэрлэлд “Гост стандарт”-ыг
ашиглах зөвшөөрлийг албан
ёсоор авч, хэрэглэж эхлэв

2017 он

Хувьцаат компани болж Монголын
хөрөнгийн зах зээлд хөл нийлүүлэв



2011 он

Цахилгаан тоног төхөөрөмж
угсралт, суурилуулалтын
чиглэлээр үйл ажиллагаа
явуулахаар үүсгэн байгуулагдав

2025 он

Олон улсын IEC 60598-1:2020
стандарыг MNS 60598-2:2025
стандартад хөрвүүлэн
батлуулав



2021 он

Эрчим хүчний үр ашгийн
үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн
байгууллагаар магадлан
итгэмжлэгдэв

2019 он

Байгальд ээлтэй дэвшилтэд
технологи нэвтрүүлсэн
байгууллагаар шалгарч
“Ногоон гэрчилгээ” олгов

2019 он

Шинэ үйлдвэрлэл, оффисын
байрыг ашиглалтад оруулав



2014 он

Лед гэрлийн үйлдвэрийг
барьж, ашиглалтад оруулав



“АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 3 сарын 11 өдөр

Дугаар 26/04

Орхон аймаг

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалт, “Анд-Энерги” ХК-ийн дүрмийн 10-р зүйлийн 10.1, 10.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Анд Энерги” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Бямба гарагийн 14:00 цагт Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоотод байрлах үйлдвэрийн байранд хосолсон (танхим болон зайнаас) хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2026 оны 3 дугаар сарын 13-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо Улаанбаатар биржид тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Б.Тогос-Эрдэнэ)-д даалгасугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд “Анд-Энерги” ХК-ийн цахим хуудас болон Улаанбаатар үнэт цаасны биржийн цахим хуудас, өдөр тутмын сонин бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2026 оны 3 дугаар сарын 16-ны өдөр олон нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2026 оны 3 дугаар сарын 31-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин олон нийтэд мэдээлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Б.Тогос-Эрдэнэ)-д даалгасугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 03-ний өдрөөр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой гаргах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбогдох бусад баримт бичгийг бусад баримт бичгийг 2026 оны 3 дугаар сарын 21-ний өдөрт багтаан хувьцаа эзэмшигчид болон тэдгээрт үйлчилж буй брокер, дилерийн компаниудад цахим хэлбэрээр хүргүүлэх, мөн тухайн өдрөөс эхлэн 09:00-17:00 цагийн хооронд Анд-Энерги ХК-ийн үйлдвэрийн байранд ирж танилцах болон www.andenergy.mn цахим хуудас, www.facebook.com/AndEnergy facebook хуудсаар орж хурлын материалыг электрон хэлбэрээр татан авч танилцах боломжийг бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ц.Гүррагчаа)-д даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 6.1 *Танилцуулах асуудал:*
 - а. ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлангийн танилцуулга;
 - б. “Анд Энерги” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;

- с. Их наяд Аудит ХХК-ийн 2025 оны аудитлагдсан тайлангийн дүгнэлтийн танилцуулга;
- d. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийн танилцуулга;
- e. “Анд Энерги” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх тухай тогтоолын танилцуулга

6.2 Хэлэлцэх асуудал:

- 1. “Анд Энерги” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - 2. “Анд Энерги” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг сонгох тухай
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах дарга болон зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Хурлын дарга:

ТУЗ-ийн дарга - Т.Барс

Комиссын дарга:

Гүйцэтгэх захирал - Ц.Гүррагчаа

Комиссын гишүүд:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга - Б.Тогос-Эрдэнэ;

Хүний нөөцийн менежер - Э.Ариунсайхан

Үйлдвэрийн мастер - Х.Батсуурь

Борлуулалтын менежер - Х.Уянга-Эрдэнэ

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

ТУЗ-ийн хараат бус гишүүн – Ш.Эрдэнэцэцэг;

Комиссын гишүүд:

Санхүүгийн менежер - П.Бямбасүрэн

Ерөнхий нягтлан бодогч - С.Алтанцэцэг;

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1, хурлын танилцах баримт бичгийн жагсаалт болон хурлын дэгийг Хавсралт №2, Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт №3, Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тогтоолын төслийг Хавсралт №4, Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тогтоолын төслийг Хавсралт №5, ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай тогтоолын төслийг Хавсралт №6-аар тус тус баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хосолсон (танхим болон зайнаас) хэлбэрээр зохион байгуулж байгаатай холбогдуулан **MI SURVEY** программыг цахим бүртгэл, санал хураалт явуулахад ашиглахыг зөвшөөрсүгэй.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хосолсон (танхим болон зайнаас) хэлбэрээр зохион байгуулахтай холбоотой программ хангамжийн бэлтгэл ажлыг хангахыг Гүйцэтгэх захирал (Ц.Гүррагчаа)-д даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилсан байдлаар 2026 оны 4 дүгээр сарын 17-ноос 2026 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн 17:00 цаг хүртэлх хугацаанд Орхон

аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баянзам 3-4,6 тоотод байрлах үйлдвэрийн байранд урьдчилан авах боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс (Ц.Гүррагчаа)-д даалгасугай.

13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг цаасан болон цахим хэлбэрээр авч, нэгдсэн тооллогын үр дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Тооллогын комиссын дарга (Ш.Эрдэнэцэцэг)-д даалгасугай.
14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад шаардлагатай материалыг Компанийн тухай хууль болон бусад холбогдох журамд заасан хугацаанд Улаанбаатар бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Б.Тогос-Эрдэнэ)-д даалгасугай.
15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг компаниас гаргахыг хурал зохион байгуулах комиссын дарга (Ц.Гүррагчаа)-д зөвшөөрсүгэй.

ТУЗ-ИЙН ДАРГА



Т.БАРС

“АНД ЭНЕРГИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

“Анд Энерги” ХК нь ТУЗ-ийн 2026 оны 3 сарын 11-ний өдрийн 26/04 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хосолсон (танхим болон зайнаас) хэлбэрээр хуралдуулах болсныг зарлаж байна. Хувьцаа эзэмшигч та Анд-Энерги ХК-ийн үйлдвэрийн байранд ирж хуралд танхимаар оролцох боломжтой.

Компанийн оноосон нэр: Анд-Энерги ХК

Хурал хуралдуулах өдөр, цаг: 2026 оны 4 сарын 25-ны өдрийн 14:00 цагт Анд-Энерги ХК-ийн үйлдвэрийн байранд болон www.facebook.com/AndEnergy цахим хуудсаар хуралдана.

ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. “Анд Энерги” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх дүгнэлтийг хэлэлцэн батлах;
2. “Анд Энерги” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг сонгох тухай

БҮРТГЭЛИЙН ӨДӨР: 2026 оны 4 сарын 03-ны өдөр

Хувьцаа эзэмшигч та 2026 оны 4 сарын 1-ний өдрөөс 2025 оны 4 сарын 24-ны өдөр хүртэл ажлын өдрүүдэд 9:00-17:00 цагийн хооронд Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоот ажлын байранд хүрэлцэн ирэх эсвэл компанийн Andenergy.mn болон өөрийн харилцдаг брокер дилерийн цахим хуудсаар хурлын материалтай танилцах боломжтой.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ ХУРЛЫН БАРИМТ БИЧГҮҮД:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл;
6. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
7. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай тогтоол

Хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоот

Утас: 77711010, 99363623, 88351298

И-мэйл хаяг: erdenetledandenergy@gmail.com

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ
ХОЛБООТОЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл	Бэлэн болох хугацаа
1	Компанийн ногдол ашиг хуваарилах тухай гаргасан ТУЗ-ийн 26/03 тоот тогтоол шийдвэр	2026.02.13
2	“Анд-Энерги” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2026 оны 3 сарын 11-ний өдрийн 26/04 тоот тогтоол	2026.03.13
3	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл	2026.03.13
4	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар	2026.03.13
5	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг	2026.03.13
6	Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар	2026.03.13
7	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл	2026.03.13
8	Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан	2026.03.21
9	Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, хөндлөнгийн аудитын дүгнэлт	2026.03.05
10	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлт	2026.03.13
11	Компанийн ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулга	2026.03.21



“АНД-ЭНЕРГИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хурал хуралдах огноо: 2026 оны 4 сарын 25-ны өдрийн 14:00 цагт

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хурлын ирцийг бүртгэх	10 минут	Зохион байгуулах комисс
2	Хурлын ирцийг мэдээлэх	5 минут	Тооллогын комисс
3	Хурлын дарга хурлыг нээх	5 минут	Хурлын дарга Т.Барс
4	Хурлын дэг болон хэлэлцэх асуудлуудыг танилцуулах	5 минут	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Тогос-Эрдэнэ
5	ТУЗ-ийн 2025 оны ажлын тайлан танилцуулах	5 минут	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Тогос-Эрдэнэ
6	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн товч тайланг танилцуулах	15 минут	Гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаа
7	Их наяд Аудит ХХК-ийн 2025 оны аудитлагдсан тайлангийн дүгнэлтийг танилцуулах	5 минут	Аудит, эрсдэлийн хороо
8	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах	5 минут	ТУЗ-ийн дарга Т.Барс
9	Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн тогтоол шийдвэрийг танилцуулах	5 минут	ТУЗ-ийн дарга Т.Барс
10	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга	15 минут	Нэр дэвшүүлэх хороо
11	Асуулт хариулт	15 минут	Зохион байгуулах комисс
12	Хурлын завсарлага, санал тоолох	15 минут	Тооллогын комисс, Зохион байгуулах комисс
13	Санал хураалтын дүнг хуралд оролцогчдод танилцуулах /ХЭ-ийн Хурлын тогтоол/	10 минут	Тооллогын комисс, Хурлын дарга Т.Барс
14	Хурлыг хаах	5 минут	Хурлын дарга Т.Барс

Жич: Шаардлагатай бол хурлын хугацааг сунгаж болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: овогтой

Регистрийн дугаар:

Хувьцаа эзэмшигчдийн хурал:

Санал өгөх хувьцааны тоо:

Үнэт цаасны компанийн нэр:

Анд-Энерги ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 сарын 25-ны өдрийн 14:00 цагт Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоотод байрлах “Анд-Энерги” ХК-ийн өөрийн байранд

Хосолсон (танхим болон зайнаас) хэлбэрээр

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах	☐	☐	☐
2	Компанийн 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах	☐	☐	☐

Санал өгсөн түүх

IP хаяг	Хөтөч	Хост	Огноо
1			

2026 оны 4 сарын 25-ны өдөр

АНД-ЭНЕРГИ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: *овогтой*

Регистрийн дугаар:

Хувьцаа эзэмшигчдийн хурал: *Ээлжит*

Санал өгөх хувьцааны тоо

Үнэт цаасны компанийн нэр:

Кумулятив саналын тоо:

Анд-Энерги ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 сарын 25-ны өдрийн 14:00 цагт Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян зам 3-4,6 тоотод байрлах “Анд-Энерги” ХК-ийн өөрийн байранд

№	ТУЗ-д нэр дэвшигчдийн нэрс	
	Ердийн гишүүд	Таны ердийн гишүүнд өгөх кумулятив саналын тоо:
1		
2		
3		
4		
	Хараат бус гишүүд	Таны хараат бус гишүүнд өгөх кумулятив саналын тоо:
1		
2		
3		
4		
5		
Өгөх ёстой кумулятив саналын тооны нийлбэр дүн:		

Санамж: ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана.

*Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй (100*9 гишүүн=900) болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн энгийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.*

Санал өгсөн түүх

IP хаяг	Хөтөч	Хост	Огноо
1			

“АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4 сарын 25 өдөр

Дугаар 01

Орхон аймаг

ТӨСӨЛ

*Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн
талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 2026 оны 4 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Анд-Энерги” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Т.БАРС

“АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4 сарын 25 өдөр

Дугаар 02

Орхон аймаг

ТӨСӨЛ

*Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх
ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 2026 оны 4 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Анд-Энерги” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Т.БАРС

“АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 4 сарын 25 өдөр

Дугаар 03

Орхон аймаг

ТӨСӨЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 2026 оны 4 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анд-Энерги ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдэд
 1. овогтой
 2. овогтой
 3. овогтой
 4. овогтой
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүдэд
 1. овогтой
 2. овогтой
 3. овогтой
 4. овогтой
 5. овогтой нарыг

2026 оны 4 сарын 25-ны өдрөөс эхлэн 2028 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл 2 жилийн хугацаагаар **сонгосугай.**

ХУРЛЫН ДАРГА

Т.БАРС

“АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 3 сарын 11 өдөр

Дугаар 26/05

Орхон аймаг

Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланд дүгнэлт өгөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 2026 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” хэмээн дүгнэсүгэй.
2. Компанийн үйл ажиллагааны тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулахыг ТУЗ-ийн дарга (Т.Барс)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Т.БАРС

“АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 3 сарын 11 өдөр

Дугаар 26/06

Орхон аймаг

Компанийн 2025 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.6.12 дахь заалт, 2026 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2025 оны санхүүгийн тайланг “Хангалтгүй” хэмээн дүгнэсүгэй.
2. Компанийн аудитлагдсан санхүүгийн тайлан түүнд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулахыг ТУЗ-ийн дарга (Т.Барс)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Т.БАРС

“АНД-ЭНЕРГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 2 сарын 13 өдөр

Дугаар 26/03

Орхон аймаг

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5 дахь заалтууд, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, 2026 оны 2 дугаар сарын 13-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Анд-Энерги” ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 1.2 төгрөг буюу нийт 93,684,693.6 төгрөг (ерэн гурван сая зургаан зуун наян дөрвөн мянга зургаан зуун ерэн гурван төгрөг зургаан мөнгө)-ний ногдол ашгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан Хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар ногдол ашиг олгох сүүлийн өдрийг 2026 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөр тогтсугай.
4. Энэхүү тогтоолыг Улаанбаатар үнэт цаасны биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Тогос-Эрдэнэ/-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Галхүү/, Хувьцаа эзэмшигчдийн хурлын комисс болон Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Т.БАРС



**ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ
АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ
БАРИМТ БИЧГҮҮД**





2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хэрэгжүүлсэн төслүүд

Бид 2025 онд гудамж, зам, талбайн гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл, үсгэн хаяг, Цамхагт гэрэлтүүлэг, дэд станц барих зэрэг жижиг болон томоохон хэмжээний мэргэжлийн 25 төсөлт ажлыг гүйцэтгэв. Үүний дотор цар хүрээ, ач холбогдол өндөртэй 12 төсөлт ажлыг хугацааны хоцрогдолгүйгээр чанарын өндөр түвшинд гүйцэтгэж хүлээлгэн өгч ажиллаа.

Орхон аймаг, Жаргалант сум 1,4км авто замын гэрэлтүүлгийн ажил



Орхон аймаг, Баян-Өндөр сум, Эрдэнэ багт АТП-45 станцад ухаалаг тоолуур суурилуулах ажил



Хэрэгжүүлсэн төслүүд

Орхон аймаг, Баян-Өндөр сум, ЭБЦТС ТӨХК, Эрдэнэт-Ус ДТС ОНӨХ-ийн нийт 25ш 6/0.4 кВ-ын трансформаторыг 10/0.4 кВ-ын трансформатороор сольж барих ажил



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Орхон аймаг, Баян-Өндөр сум, РП-201, 202 дэд станцуудын реле хамгаалалтыг скадад холбох ажил



Орхон аймаг, Баян-Өндөр сум, Чингэл, Баянцагаан байгуудад КТПН дэд станцууд барих ажил



Эрдэнэт хотноо зохион байгуулагдсан “Зэс фестиваль-ийн гэрлэн чимэглэл хийх ажил



Орхон аймгийн сүлд модны гэрлэн чимэглэл



Онцлох үйл явдал

2025 онд бидний хувьд шинэ боломж, шинэ хөгжлийг авч ирэх томоохон, онцлох үйл явдлууд цөөнгүй болж өнгөрлөө. Тухайлбал:

- ✓ Эрчим хүчний зохицуулах хороо, Стандарт хэмжилзүйн газруудтай байгуулсан гэрээний хэрэгжилт биеллээ олж Монгол улсад анх удаа Европын гэрэлтүүлгийн стандартыг нэвтрүүлэхээр зорьсон зорилго минь нэг шат ахиж стандарт батлагдав. Энэхүү стандартаар дамжуулан гэрэл гэдэг зүйл зөвхөн гэрлтүүлдэг биш илүү өргөн хүрээний, мэргэжлийн түвшний ойлголт гэдгийг хүргэхийг зорьж байна.
- ✓ Үйлдвэрлэдэг гэрэлтүүлгүүдийн түүхий эд, дагалдах материалуудыг шинэчлэх, турших ажлуудын үр дүнд гэрэлтүүлгийн үр ашгийн үзүүлэлт сайжрав.
- ✓ Монгол улсад цорын ганц гэрэлтүүлгийн лабораторийн үйл ажиллагаа өргөжих үндэс суурь тавигдлаа. Лабораторийг идэвхтэй ажиллуулах нь стандартыг мөрдөх, чанарын өндөр түвшний үзүүлэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэс суурь болох юм.

MNS MNS 60598-2:2025 “Гэрэлтүүлгийн стандарт” батлагдав

Стандарт хэмжилзүйн газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 0/29 тоот тушаалаар гэрэлтүүлгийн 2-р стандарт батлагдлаа.



Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг баталгаажуулж “Тохирлын гэрчилгээ”-тэй болов



Онцлох үйл явдал


Бүтээгдэхүүний үр ашгийн үзүүлэлтийг нэмэгдүүлэв.

Бүтээгдэхүүний түүхий эд болоод дагалдах материалыг шинэчлэх, турших ажлууд хийгдсэний үр дүнд гэрэлтүүлгийн гэрлийн урсгал, бодит чадал, үр ашгийн индекс сайжирч 24 бүтээгдэхүүнээс 15 бүтээгдэхүүнийг С түвшинд хүргэлээ.

D
24 бүтээгдэхүүн



C
15 бүтээгдэхүүн



Хойд бүсийн анхдугаар зөвлөгөөнд оролцов

2025.04.28-ий өдрүүдэд Булган аймагт зохион байгуулагдсан Хойд бүсийн анхдугаар зөвлөгөөнд хамт олноороо оролцож бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулав.



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Онцлох үйл явдал

Хойд бүсийн эдийн засгийн форумд оролцов

2025.05.06-ны өдрүүдэд Эрдэнэт хотноо зохион байгуулагдсан Хойд бүсийн Эдийн засгийн форумд оролцов.



Шилдэг татвар төлөгч болов.

Монгол улсын татварын хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж Орхон аймгийнхаа бүтээн байгуулалт, хөгжил цэцэглэлтэд бодитой хувь нэмэр оруулсныг үнэлэн Монголын татварын албанаас оны шилдэг татвар төлөгч болсныг 2025.05.06-ны өдөр гардуулан өгөв.



Сэтгүүлч нар манай үйлдвэрт зочлов

Эдийн засгийн форумыг сурвалжлан Монгол улсын өнцөг булан бүрээс ирсэн сэтгүүлч нар манай үйлдвэрээр зочлон танилцав.



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нийгмийн хариуцлага

Нийгмийн хариуцлагын хүрээнд дараах байгууллага, аж ахуй нэгжүүдэд хандив тусламж үзүүлэв. Үүнд:

- ❖ Сэлэнгэ аймаг Хушаат суманд үүссэн гал, түүмрийг унтраахад мөнгөн тусламж
- ❖ Орхон аймгийн Авто тээврийн төвийн тохижилт үйлчилгээнд зориулан мөнгөн тусламж
- ❖ Баян-Өндөр сумын Уртын гол багийн хүүхдүүдийн баярт хандив, мөнгөн тусламж



Сургалт, хөгжил

Анд-Энергичүүд бид мэдлэг, чадвар, туршлагаа нэмэгдүүлэх, цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхах зорилгоор гадаад болон дотоод сургалтуудыг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна.



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Байгальд ээлтэй бүтээгдэхүүн

Бид байгуулагдсан цагаасаа эхлэн байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж ирсэн бөгөөд LED гэрлүүд нь дараах давуу талуудтай Үүнд:

- Эрчим хүч хэмнэх
- CO₂ ялгаруулалтыг бууруулах үүн дотор материалын хэрэглээг багасгаж, Мөнгөн усны хэрэглээг бууруулах хог хаягдлыг багасгах өндөр ач холбогдолтой юм.



2024 онд бидний үйлдвэрлэсэн 1509ш гадна гэрэлтүүлэг нь 5757 модны шингээх нүүрс хүчлийн хийтэй тэнцэх буюу 132,414 кг CO₂ агаар мандалд хаяхаас сэргийлж, байгаль орчноо хамгаалахад хувь нэмэр оруулсан. Харин энэ үр дүн 2025 онд 2 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Тухайлбал 2025 бид гадна гэрэлтүүлгийн үйлдвэрлэлийг 2 дахин нэмэгдүүлж, судалгаа хөгжүүлэлтийн уйгагүй ажлын үр дүнд өөрсдийн бүтээгдэхүүний эрчим хүчний үр ашгийн зэрэглэлийг 1-2 түвшин ахиулснаар өмнөхөөс 25%-р илүү хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж хэрэглэгчиддээ хүргэсэн нь 15,352 модны шингээх нүүрс хүчлийн хийтэй тэнцэх буюу 353,104 кг CO₂ агаар мандалд хаяхаас сэргийлжээ.




БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд

Үйлдвэрлэсэн гэрэлтүүлэг
/ширхэг/Гүйцэтгэсэн мэргэжлийн
ажил, үйлчилгээ

Ажиллах хүчний тоо



Үндсэн хөрөнгө /сая.төг/



Нийт борлуулалтын орлого
/сая.төг/

Төлсөн татвар /сая.төг/



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд



Гүйцэтгэх удирдлагын баг

Анд-Энерги ХК-ийн Гүйцэтгэх захирал
Цэнд-Аюушийн **Гүррагчаа**
Уулын цахилгаан механик тоног төхөөрөмжийн
инженер, Монгол улсын мэргэшсэн инженер



Санхүү төлөвлөлт, Борлуулалтын алба хариуцсан
менежер, Санхүүгийн менежер
Пүрэвдоржийн **Бямбасүрэн**
Даатгалын эдийн засагч, Бизнесийн удирдлагын
магистр

Захиргаа, аж ахуйн алба хариуцсан менежер,
Хүний нөөцийн менежер Энхболдын **Ариунсайхан**
Нийгмийн ажилтан, Хүний нөөцийн менежментийн
магистр



Ерөнхий нягтлан бодогч
Сарантуяагийн **Алтанцэцэг**
Банкны эдийн засаг, Нягтлан бодох бүртгэл



2025 ОНЫ САНХҮҮГИЙН АУДИТЛАГДСАН ТАЙЛАН



Хараат бус аудиторын дүгнэлт



ИХ НАЯД АУДИТ
 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХАРААТ БУС ИТГЭМЖЛЭГДСЭН
 ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГА

Улаанбаатар хот, СБД, 8-р хороо, River

Castle Business Apartment 605 тоот,

Утас: +976 99077062, 9666-4168

И-мэйл: audit@ikhnayad.mn

2026.03.02 № СТА - ХК - 15/03

“АНД-ЭНЕРГИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ

Бид “АНД-ЭНЕРГИ” ХК (цаашид “компани” гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүү байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “АНД-ЭНЕРГИ” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудит хийхдээ Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус компанийн талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул компанийн тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл, бүртгэлийн суурь, бодлогын өөрчлөлтөд тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй болно.

СТА-ХХК-26/256



САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Компанийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

